



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар A/133

Арвайхээр

Арвайхээр Засаг даргын Тамгын газрын
бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, 33.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газрын орон тооны дээд хязгаарыг тогтоож, бүтэц, орон тоог хавсралтаар баталсугай.

2. Хуульд заасан эрх хэмжээний дагуу сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдийн албан тушаалын чиг үүргийг тодорхойлон, хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга (О.Пүрэвдорж), Засаг даргын Тамгын газрын дарга (Т.Чинзориг) нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т үүрэг болгосугай.

3. Шинээр батлагдсан бүтэц, орон тоог 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга (О.Пүрэвдорж)-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан “Арвайхээр сумын Засаг даргын Тамгын газар, хотын захирагчийн албаны бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай” 2018 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/501 дүгээр захирамжийн нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100303

Аймгийн Засаг даргын 2019 оны 03
дугаар сарын 10-ны өдрийн 1133 дугаар
захирамжийн хавсралт

АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО

№	Албан тушаалын нэр	Орон тоо
1.	Засаг дарга	1
2.	Засаг даргын орлогч	1
3.	Тамгын газрын дарга	1
4.	Санхүүгийн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч	1
5.	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	2
6.	Төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн	1
7.	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн	1
8.	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	1
9.	Гэр бүл, хүүхэд, залуучууд, нийтийн биеийн тамир хариуцсан мэргэжилтэн	1
10.	Хүнс, газар тариалан, хоршоо, экстэйншн, үйлчилгээний салбарын асуудал хариуцсан мэргэжилтэн	1
11.	Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологи, малын үржил бүртгэл, бэлчээр, тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
12.	Жижиг, дунд үйлдвэрлэл, сум хөгжүүлэх сан, үндсэн чиглэл, төсөл, хөтөлбөр, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн	1
13.	Нийгмийн ажилтан	1
14.	Хэвлэл мэдээллийн ажилтан	1
15.	Хөдөлмөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн	1
16.	Угтах үйлчилгээний ажилтан	1
17.	Нягтлан бодогч	1
18.	Багийн Засаг дарга	13
19.	Багийн зохион байгуулагч	13
20.	Багийн нийгмийн ажилтан	11
21.	Архив, бичиг хэргийн эрхлэгч	1
22.	Нярав	1
23.	Үйлчлэгч	2
24.	Жолооч	1
25.	ЗДТГ-ын жижүүр	4
26.	Багийн жижүүр	5
Бүгд		69